

**СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 07 ДУГААР САРЫН МЭДЭЭ
б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:**

7 дугаар сард сумын Онцгой комисс нийт 2 удаа хуралдлаа.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл хөтөлбөрийн ажлын хэсгийн эрэмбэлсэн жагсаалт, тайланг ЗД-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээ.

Хагас жилийн ХШҮ ний тайланг 7 дугаар сарын 20 ны өдөр Засаг даргын зөвлөлд танилцуулан, зөвлөмж чиглэл авч ажиллалаа.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

7 дугаар сард аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 44732300 төгрөгийн санхүүжилт ирж орон нутгийн төсөвт байгууллагуудад 47315200 төгрөгийн санхүүжилтийг өглөө.

- Хагас жилийн санхүүгийн тайланг төсөвт 6 байгууллага, тусгай сан 4, Халзан дулаан ОНӨҮГ нийт 11 байгууллага хуулийн хугацаанд / 7.25 дотор / гарган сангийн яамны сайтад шивж нэгтгэлээ.
- Төсөвт 6 байгууллагын 2022 оны төсвийн төслийг хийж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлээ.
- 2022 оны төсвийн төслийг цахимаар хийж холбогдох газарт хүргүүлсэн.

**ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

Ерөнхий боловсролын сургууль: Хичээл сургалт эрт амарсантай холбогдуулан багш ажилчдын ээлжийн амралт эхлэсэн. Ажиллаж байсан албан хаагчид байгууллагын гадна орчны зэрлэгийг зулгаах, хүнсний ногоог услаж арчлан ажиллаж байна.

Удирдах ажилтан болон бусад багш ажилчид хэдийгээр амарсан ч БСУГ болон яам, ЗДТГ-т шаардлагатай мэдээ судалгаа, хугацаатай албан бичиг, тайланг хүргүүлэн ажилласан.

Эрүүл мэндийн төв: Эрүүл мэндийн төв нь 7 сард батлагдсан тохиолдол болох 34 иргэнийг эмнэлэгт эмчилж гаргасан. Улаан бүсэд 1 эх баригч 1 үйлчлэгч 1 сувилагч ажилласан. Тандалтын 2 баг ажиллаж батлагдсан иргэдийн ар гэрийн

ойрын хавьтал тогтоох ариутгал халдваргүйтгэл хийх , 1 өрх 1 шинжилгээ зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

АНЭ ийн лаборторид PCR 120 шинжилгээ хүлээлгэн өгсөн.

1 өрх 1 шинжилгээгээр 300 хүнээс шинжилгээ авч ажилласан.

Хэвтсэн 34 хүний биеийн байдал 6 иргэн хүндэвтэр 28 иргэн хөнгөн байлаа. Үүнээс 11 хүүхэд 23 том хүн байсан.

12 наснаас 15 насны нийт 60 хүүхдэд Файзер вакцины 1 р тунг 7 дугаар сарын 19-20 хооронд хийлээ. Мөн 16, 17 настай 42 хүүхдэд 1 болон 2 тунг хийж дархлаажуулсан.

3 эмчлэх байр 9 өрхөд нийтдээ давхардсан тоогоор 2500 М 2 урьдчилан сэргийлэх болон голомтын ариутгал хадваргүйтгэл хийсэн.

Мөн ЭМГ болон Мэргэжлийн хяналтын албанд мэдээ тайланг цаг тухай бүрт явуулж байна. Дээд газрын тушаал шийдвэрүүдийг цаг тухай бүрт татан авч сургалт хийж ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна .

ЭМТ ажилчид амбулаторийн үзлэгийг багасаж гэрийн эргэлтэнд шилжүүлж айл өрхүүдээр зөвлөгөө зөвлөмж, Яаралтай үед холбогдох мэргэжилтэнгүүдийн утасны дугаар,зэргийг хэвлэн тараасан. Хөдөөгийн айл өрх дөө утсаар зөвлөгөө өгч баг хорооны дарга нартай хамтран ажиллаж байна .

ЭМЯам болон ЭМГ, АНЭ хамтран цахим сургалтанд байнга холбогдож байна.

Мал эмнэлэг : Аймгийн мал эмнэлгийн газрын дарга Молорчимэг, МАЭМА-ны дарга С.Мөнх-эрдэнэ, Улсын байцаагч Г.Мөнхзул нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 7 дугаар сарын 09 ны өдөр тус суманд ажиллаж 2020 оны хийсэн ажлын тайлан, тарилгын гүйцэтгэлтэй танилцаж, 2021 онд хийж хэрэгжүүлэх ажлын тайлан, мэдээ хийж хэрэгжүүлж байгаа ажлын гүйцэтгэл, МЭ-ийн цахим системийн төлөвлөт, гүйцэтгэлтэй танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдахаар төлөвлөгдөж байсан 4 угаалгын ванны ажил хийгдэж эхлээд байна. 1-р багийн малгар гэх газарт шүүт мал эмнэлгийн малын эмч Э.Энхболдын угаалгын ванн баригдаж дуусаад Сумын засаг дарга, мал эмнэлгийн тасгаас хүлээж аваад байна. Мөн 1-р багийн

Баянбулгын угаалгын ванн чанар стандартын шаардлага хангахгүй болсон учир шинээр ванн баригдахаар болж ажил эхлээд 30 хувьтай явагдаж байна.

Шүлхий мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын тандалт судалгааг зүүн 3 аймагт хийгдэх болсонтой холбогдуулан манай сумаас 8 өрх сонгогдож 1 өрхөөс 16 дээж авч нийт 128 цусны ийлдсийг аймгийн мал эмнэлгийн газарт зохих баримтын хамт хүргүүлээд байна.

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:

М.БАТБЭХ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.ДАЙРИЙМАА